



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/398

Булган сум

Булган аймгийн төвийн эвдрэлтэй камерыг
засварлахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны хуралдааны VII/38 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Амар тайван Булган" хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Булган аймгийн төвийн эвдрэлтэй камерыг засварлахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Камерыг засварлах, шинээр суурилуулахад шаардлагатай 4,800,000 (дөрвөн сая найман зуу мянга) төгрөгийг "Амар тайван Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Камерыг засварлах ажлыг чанартай хийж гүйцэтгэж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Телекамерын хяналтын дэд төвийн дарга (Г.Насантогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

